



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/618

Хэрлэн сум

Насанд хүрээгүй хохирогчид хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3 дахь заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.7 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 27 дугаар хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний 6 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд Насанд хүрээгүй, бэлгийн хүчирхийллийн хохирогч 231024053009-108 кейс дугаартай Г овогтой Г, 23016324060610 кейс дугаартай О овогтой П нарын өмгөөллийн зардалд зориулан 2,000,000 (хоёр сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хүүхдэд ээлтэй орон нутаг болно” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ